



НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2014 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/04

Улаанбаатар хот

Шинжлэн шалгах багийг томилох тухай

Иргэний нисэхийн тухай Монгол улсын хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2, Иргэний нисэхийн багц дүрэм 203-ын 8.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. JU-9917 бүртгэлийн дугаартай Dash 8 Q400 агаарын хөлөг 2014 оны 03 дугаар сарын 28-ны өдөр Техник үйлчилгээний ажил дээр гарсан зөрчил, 2014 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр Нислэгийн параметр дээр гарсан зөрчлийн шалтгааныг тогтоох шинжлэн шалгах багийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Шинжлэн шалгах багийн ахлагч: М.Баатаржав, Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны шинжээч

Гишүүд: О.Бат-Орших, нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны шинжээч

И.Энхчулуун, нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны шинжээч

Нарийн бичгийн дарга: А.Ууганбаяр, нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны мэдээлэл судалгааны мэргэжилтэн

2. Шинжилгээний ажилд шаардлагатай мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулахыг багийн ахлагч (М.Баатаржав)-д зөвшөөрсүгэй.

3. Шинжлэн шалгах ажиллагааг Чикагогийн конвенцийн 13 дугаар хавсралт, Осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны зааврын дагуу хийж гүйцэтгэж, үйл ажиллагааны явцыг цаг тухайд нь танилцуулж байхыг багийн ахлагч (М.Баатаржав)-д үүрэг болгосугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



Ж.ЦОЛМОН

2014 00005



НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2014 оны 11 сарын 26 өдөр

Дугаар А/11

Улаанбаатар хот

Шинжлэн шалгах багийг томилох
тухай

Иргэний нисэхийн тухай Монгол улсын хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2, Иргэний нисэхийн багц дүрэм 203-ын 8.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. JU-2032 бүртгэлийн дугаартай Л-410 УВП агаарын хөлөг 2014 оны 07 дугаар сарын 29-ний өдөр Өмнөговь аймгийн Даланзадгад хотын нисэх буудалд нислэг үйлдэх үед зүүн хөдөлгүүрийн турбинд бүтцийн гэмтэл гарсан ноцтой зөрчлийн шалтгааныг тогтоох шинжлэн шалгах багийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Шинжлэн шалгах багийн ахлагч: И.Энхчулуун, Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны шинжээч

Гишүүд: О.Бат-Орших, Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны шинжээч

П.Гэрэлчимэг, Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны бичлэг тайлах мэргэжилтэн

2. Шинжлэн шалгах ажиллагааг Чикагогийн конвенцийн 13 дугаар хавсралт, Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны зааврын дагуу хийж гүйцэтгэхийг багийн ахлагч (И.Энхчулуун)-д үүрэг болгосугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



Ж.ЦОЛМОН

2014 00024